



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчигээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XVII.1.2.7 Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний хүрээнд Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 451 дүгээр тушаалаар батлагдсан Сумдын эрүүл мэндийн төвийн их засвар /Говь-Алтай/ ажлын 500,000,000 /Таван зуун сая/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Говь-Алтай аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Говь-Алтай аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080030